



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2013 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Г Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын
дүрмийн холбогдох заалтанд өөрчлөлт
оруулах, бүтэц, орон тоог шинэчлэн
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 190 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2009 оны 221 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дүрмийн 2.2, 2.5 дахь заалтын “Орлогч дарга” гэснийг “Дэд дарга-Ерөнхий инженер” гэж шинэчлэн өөрчилж, газрын бүтэц орон тоог хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Бүтэц, орон тоог шинэчлэн баталсантай холбогдуулан ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт болон орон тоонд ажилтнуудыг ажилд авах, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу олгохыг Нийтлэг үйлчилгээний газар /Ш.Одончимэг/-т үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2009 оны 14 дүгээр захирамжийн хавсралтын 16 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ

D:\2012 захирамж\Дүрэм.docx

111020000217

Нийслэлийн Засаг даргын 2013 оны
01 дугаар сарын *18*-ны өдрийн
А/ЗН дугаар захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН БҮТЭЦ ОРОН ТОО

№	Хэрэгжүүлэгч агентлаг	Нэгжийн нэр	Орон тооны хязгаар
1	Нийтлэг үйлчилгээний газар	Захиргааны тасаг, Санхүү-аж ахуйн алба, Инженер-техникийн алба, Үйлчилгээний алба,	280 хүртэл, үүнээс газрын дарга-1, дэд дарга-ерөнхий инженер-1,